



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 16

Хажуу шинэ-Ус

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон
шалгаруулах тов зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.10 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус гуравдугаар хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хүлээн авах ажлыг 2023 оны 08 дугаар сарын 15 -ны өдрөөс эхлэн 2023 оны 09 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.

2. Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн санал хүлээн авах, сонгон шалгаруулахдаа журмын 2 дугаар зүйлийг мөрдлөг болгон ажиллахыг төсөл сонгон шалгаруулах хороо (Н.Өлзийтогтох)-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Булган)-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ПҮРЭВСЭНГЭ



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ ТӨСЛИЙГ 2023 ОНЫ
НАЙМДУГААР САРЫН 15-НЫ ӨДРӨӨС 09 ДҮГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙГ ХҮРТЭЛ 30
ХОНОГИЙН ТУРШ ХҮЛЭЭН АВНА

2023.08.15

Хажуу Шинэ Ус

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын дагуу Хөнгөлөлттэй зээл авах төслийн саналыг 2023 оны 08 дугаар сарын 15-аас өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд ЗДТГ-ын дарга хүлээн авна.

Төслийн саналд дараах шаардлагыг хангасан Хоршоо, Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч /ЖДҮҮЭ/, Иргэн хамрагдах боломжтой. Үүнд:

1. Тухайн суманд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг байх
2. Монгол банкны зээлийн мэдээллийн санд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх
3. Зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх
4. Хоршоолох үйл ажиллагаа болон жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэх талаар зохих мэдлэг, туршлагатай байх
5. Хоршоо нь хоршооны тухай хуульд заасны дагуу хоршоодын холбоонд элсэж тодорхойлолт авсан байх
6. ЖДҮҮЭ нь Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 6.1-д заасан байгууллагад бүртгүүлж тодорхойлолт авсан аж ахуйн нэгж байх
7. Иргэний хувьд 2-4 заасан шаардлагаас гадна тухайн суманд 3-аас доошгүй жил оршин суусан хувиара хөдөлмөр эрхлэгч байх

2023 ОНД ХӨНГӨЛӨЛТТЭЙ ЗЭЭЛ ОЛГОХ САЛБАР:

- Орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгал, гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэл /арьс шир, суран эдлэл /
- Хүнсний ногоо тариалах
- Малын тэжээлийн ургамал тариалах
- Хоёрдогч түүхий эд боловсруулах, хог хаягдал ангилан ялгах
- Хөдөө аж ахуйн түүхий эд, мал мах худалдан авах
- Модон эдлэл
- Нэмэлт мэдээлэл авах утасны дугаар - 88995408, 89141516

